- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд санхүүгийн хяналт, дотоод аудит хийгдээгүй хэдий ч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,705,744.7 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,957.4	125,437.2	113,479.80
Бараа материал	156,173.1	157,214.2	1,041.10
Үндсэн хөрөнгө	2,001,727.4	4,592,951.2	2,591,223.80

<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,169,857.9</b>	<b>4,875,602.6</b>	<b>2,705,744.70</b>
Өр төлбөр	11,957.4	123,017.0	111,059.60
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,157,900.5	4,752,585.6	2,594,685.10
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,169,857.9</b>	<b>4,875,602.6</b>	<b>2,705,744.70</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын данс 125,437.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, 113,479.8 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны татаас санхүүжилтийн авлагаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,592,951.2 мянган төгрөг болж, 2,591,223.80 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвөөс 100,329.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, ТӨБЗГ-ын 2023 оны 604 дүгээр тогтоолоор “Засгийн газрын автобааз” ТӨҮГ-аас 79,741.6 мянган төгрөгийн Ниссан теана маркын автомашин, ОБЕГ-аас 88,280.0 мянган төгрөгийн Киа бонго, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 194,500.0 мянган төгрөгийн Тоёото прадо болон хайс маркын тээврийн хэрэгслийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон тайлант онд газрыг 2,221,632.0 мянган төгрөгөөр үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэснээс,
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 123,017.0 мянган төгрөг болж, 111,059.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төвлөрүүлсэн татаас санхүүжилтийг өр төлбөрөөр бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

ЗДТГ-ын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 5,727,649.4 мянган төгрөг, өөрийн орлогоос 45,000.0 мянган төгрөг, нийт 5,772,649.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 1,627,798.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 7,400,448.3 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 41,100.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 7,400.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 249,456.4 мянган төгрөгөөр,
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 654,863.5 мянган төгрөгөөр,
- Уналга, цугларалт бэлтгэл сургалтын зардлыг 40,000.0 мянган төгрөгөөр,
- Орон нутгийн нөөц хөрөнгийн төсвийг 1,055,273.8 мянган төгрөгөөр,
- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлсийг 50,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,

- Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 317,880.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 17,041.9 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 66,198.4 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 56,954.1 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл сурталчилгааны зардлыг 2,500.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 9,720.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан гэх мэт.

Тайлант оны дундуур батлагдсан төсвийг 201,358.5 мянган төгрөгөөр Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, 7,601,806.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,601,806.8 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс 7,556,806.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 45,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 6,317,319.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 55,275.2 мянган төгрөг зэрэг нийт 6,372,594.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,372,594.5 мянган төгрөг буюу 83.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 724,264.8 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 233,635.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,435,912.8	2,711,648.0	724,264.8	78.9
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1,597,491.8	1,363,856.3	233,635.5	85.4
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	717,208.6	657,161.8	60,046.8	91.6
5	Зөвлөл, хороо, комиссын гишүүд /ТАСЗ/	50,000.0	49,992.0	8.0	100.0
6	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	5,500.0	5,000.0	500.0	90.9
7	Уналга, цугларалт бэлтгэл сургууль	40,000.0	39,957.5	42.5	99.9
8	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	464,061.3	378,727.5	85,333.8	81.6
9	Орон нутгийн нөөц хөрөнгө	1,256,632.3	1,131,251.4	125,380.9	90.0
10	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	35,000.0	35,000.0	0.0	100.0
	<b>Дүн</b>	<b>7,601,806.8</b>	<b>6,372,594.5</b>	<b>1,229,212.3</b>	<b>83.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 100130051415 тоот дансанд нийт 1,981,256.8 мянган төгрөгийн дараах орлогыг төвлөрүүлж, 1,816,733.9 мянган төгрөгийг 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулж, 164,522.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Засгийн газрын ХЭГ-аас арга хэмжээний зардалд 5,756.4 мянган төгрөг,
- Сангийн яамнаас Сайхан сумын Цагдаагийн газрын тоног төхөөрөмжийн зардалд 243,827.5 мянган төгрөг,
- ОНХС-аас улсын баяр наадмын зардалд 200,000.0 мянган төгрөг,
- Сэлэнгийн Онцгой байдлын газраас өвөлжилтийн хүндрэлийг бууруулах арга хэмжээнд 15,000.0 мянган төгрөг,
- ОНХС-ын чанарын баталгааны 11,849.1 мянган төгрөг /данс андуурч хийснийг буцаалгүй бүртгэж авсан/,
- Татаас санхүүжилтийн авлагын 19,503.8 мянган төгрөг,
- Архивын гэрээт ажилчдын цалинд 16,205.6 мянган төгрөг,
- Төрийн албаны зөвлөлөөс шалгалт зохион байгуулах зардалд 7,770.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын санхүүжилт 1,373,696.6 мянган төгрөг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс 75,690.4 мянган төгрөг,
- Барилгын техник хяналтын зардлын 11,957.4 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

				/мянган төгрөгөөр/
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
1	Шатахуун, шатах тослох материал	90,639.2	71,050.3	Харьцуулалтын арга
	<b>Нийт дүн</b>	<b>90,639.2</b>	<b>71,050.3</b>	

Шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендерт Шунхлай ХХК шалгарсан /5.06, 7.05, 7.25-д 3 удаа зарласан/ боловч үр дүнг цаг тухайд нь тооцоогүй, хурлыг зохион байгуулаагүй зэргээс шалтгаалан гэрээ байгуулах, эрх олгох албан бичгийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/62 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 8,263,253.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 82,632.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд үндсэн хөрөнгөд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон буюу газрыг үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэж авснаар үндсэн хөрөнгийн данс 2 дахин нэмэгдсэн бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө **4,875,602.6** мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **48,756.0** мянган төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Байр ашиглалттай тогтмол зардлыг 60,045.1 мянган төгрөгөөр,

- Бичиг хэргийн зардлыг 12,985.8 мянган төгрөгөөр,
- Сумдад ажиллах албан томилолтын зардлын батлагдсан төсвийг 20,856.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг 8 автомашинд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 49 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад хууль тогтоомжид заагдаагүй шагнал, бэлэг дурсгалын зүйлс олгосон, бараа материал нөөцөлсөн зэрэг нийт **17,100.0** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын 2024 оны “Тэргүүний ажилтан”-аар шалгарсан 10 албан хаагчийн шагналд нийт **5,400.0** мянган төгрөг,
- Байгууллагын тэргүүний хэлтсээр шалгарсан хэлтсүүдийн шагналд нийт **8,000.0** мянган төгрөг,
- Албан хаагчдад олгох 100 ширхэг бал, 100 ширхэг дэвтрийн үнэд **3,700.0** мянган төгрөг *Иөмнөх онд худалдан авсан 44.0 мянган төгрөгийн 51 ширхэг дэвтэр, 9.0 мянган төгрөгийн 30 ширхэг бал нь зарцуулагдаж дуусаагүй дансны үлдэгдлээр тайлагнасан/ гэх мэт.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;”, 15.1.6: “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ЗДТГ-ын мэдээлбэл зохих 171 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын 2024 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд шинжилгээ хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналтын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,968.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 163,760.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 93,844.4 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 88.9 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,968.0	1	3,968.0	100.0
Албан шаардлага	3	163,760.4	3	163,760.4	100.0
Зөвлөмж	5	93,844.4	4	3,024.0	80.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>261,572.8</b>	<b>8</b>	<b>170,752.4</b>	<b>88.9</b>

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр буюу төсвийг эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүйгээс зардлын бүлэг, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **43,541.3** мянган төгрөгийн дараах алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 3,813.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Үндсэн хөрөнгийн 8,753.7 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй,
- Үр дүнгийн тайланд санхүүжилтийг 30,973.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн гэх мэт.

Аудитаар нийт **71,551.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **1,669.5** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **39,175.3** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **30,706.6** мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт:**

**5.1.1.** Албан хаагчдын цалин хөлстэй холбоотой нийт **1,669.5** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Албан хаагчдыг Улаанбаатар хот, аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **820.0** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон,
- Ажилчдын бусдад өгсөн хандивыг цалингаас нь урьдчилан шилжүүлж, суутгалыг дараа нь гүйцэтгэж байгаагаас шалтгаалан **849.5** мянган төгрөгийн авлагыг дутуу суутгасан гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлт болон дутуу суутгасан авлагыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

**5.2.1.** Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **18,712.6** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Барилгын тогтмол зардлын арга хэмжээний урсгал засварын батлагдсан төсвөөс авто тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар үйлчилгээний зардалд 5,800.4 мянган төгрөг,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 10,912.9 мянган төгрөг,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлаас тавилга, эд хогшил худалдан авахад 385.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 1,006.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 202.5 мянган төгрөг зэрэг нийт 1,593.5 мянган төгрөг,
- Бичиг хэргийн зардлаас зочин төлөөлөгч хүлээн авахад 405.8 мянган төгрөг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**5.2.2.** Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгасан гэх үндэслэлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хууль тогтоомжид заагдаагүй шагнал, бэлэг дурсгалын зүйлс олгосон зэрэг нийт **17,100.0** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын 2024 оны “Тэргүүний ажилтан”-аар шалгарсан 10 албан хаагчийн шагналд нийт **5,400.0** мянган төгрөг,
- Байгууллагын тэргүүний хэлтсээр шалгарсан хэлтсүүдийн шагналд нийт **8,000.0** мянган төгрөг,
- Албан хаагчдад олгох 100 ширхэг бал, 100 ширхэг дэвтрийн үнэд **3,700.0** мянган төгрөг /өмнөх онд худалдан авсан 44.0 мянган төгрөгийн 51 ширхэг дэвтэр, 9.0 мянган төгрөгийн 30 ширхэг бал нь зарцуулагдаж дуусаагүй дансны үлдэгдлээр тайлагнасан/ гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;”, 15.1.6: “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3.** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас дараах зөрчлүүдийг гаргасан боловч санхүүгийн тайлант өр төлбөрөөр тусгаагүй **3,362.7** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэгийг Т.Мөнхтүвшин, Б.Гантуул нарт олгохдоо **1,410.6** мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй,
- Байгууллагад төлөх бараа материалын үнэ **1,952.1** мянган төгрөгийг шилжүүлэлгүйгээр өр төлбөр үүсгэсэн гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд өр төлбөрийг үнэн зөв тусгах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **5.3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **30,706.6** мянган төгрөг,
- Цалингийн зөрүү тооцооллыг тухай бүр хийж баталгаажуулаагүй, төсвийн шууд захирагчид хянуулалгүйгээр цалингийн цэсийн зөрүү баганад цалин бодож, олгож байгаа нь ажилчдын цалинг зөрүүтэй тооцож, олгох эрсдэлийг үүсгэж байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

### **5.3.2. Албан томилолтын зардлын данстай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Албан томилолтын зардлыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр буюу авлага, өр төлбөр үүсгэлгүйгээр шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтын тооцоог хүн тус бүрээр үүсгэж, хянаж байх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг дуу тусгасан.	1	3,813.9	1	3,813.9			1	3,813.9						
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй	1	8,753.7	1	8,753.7			1	8,753.7						
Үр дүнгийн тайланд санхүүжилтийг илүү илэрхийлсэн.	1	30,973.7			1	30,973.7	1	30,973.7						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>43,541.3</b>	<b>2</b>	<b>12,567.6</b>	<b>1</b>	<b>30,973.7</b>	<b>3</b>	<b>43,541.3</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин зөрүүтэй тооцож, олгосон	1	1,669.5	1	1,669.5								
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	18,712.6			1	18,712.6						

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн	1	17,100.0			1	17,100.0				
Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ер төлбөр үүсгэсэн	1	3,362.7			1	3,362.7				
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	30,706.6					1	30,706.6		
Албан томилолтыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд бүртгэсэн	1						1			
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>71,551.4</b>	<b>1</b>	<b>1,669.5</b>	<b>3</b>	<b>39,175.3</b>	<b>2</b>	<b>30,706.6</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								